



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 07

Баянбулаг

**Хоршоог хөгжүүлэх сангаас олгох
зээлийн тэргүүлэх чиглэл, дээд
хэмжээ батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3.4, Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/124 тоот захирамжийг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын IX Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн түүхий эд, нөөц боломж, давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлж орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг оновчтой зохион байгуулж хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор сумын “Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо (Загвар хоршоо)” “Газар тариалан”, “Мал, амьтны тэжээл, тариалалт, үйлдвэрлэл”, “Арьс шир боловсруулах”, “Мах махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах”, “Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, “Эрчимжсэн мал аж ахуй”, “Бэлчээрийн мал аж ахуй”, “Аялал жуулчлал”, “Орон нутгийн онцлогт брэнд бүтээгдэхүүн” үйлдвэрлэлийг тэргүүлэх чиглэл гэж үзсүгэй.

2. Төсөлд олгох зээлийн дээд хэмжээг 100 000 000 (Нэг зуун сая) хүртэлх төгрөг байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ны 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.НАМГАРРЕНЧИН



648803018